



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/218.

Булган сум

Агаарын хөлөг шувуу, мал амьтантай  
мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар  
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/97 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын 3.9, 3.9.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлагдсан “Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Булган аймаг дахь аэродром орчимд “Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Булган аймгийн Засаг даргын орлогч
Зөвлөлийн нарийн бичиг:	Булган нисэх буудлын дарга
Зөвлөлийн гишүүд:	Булган нисэх буудлын Аэродромын инженер /техникч/ Булган сумын Газрын даамал Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн дарга Булган сумын 6 дугаар багийн Засаг дарга Булган сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Булган сумын 6 дугаар багийн хэсгийн төлөөлөгч

2.“Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж хариуцлага, санаачилгатай ажиллахыг Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөлд даалгасугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн ажлын зохион байгуулалтад хуулийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/66 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010309